



Бүтээлч санал зөвлөмж

Усны газар

Вилл Гау, MERIT төслийн зөвлөх
2022 оны 9-р сарын 26-ны өдөр

Бүтээлч санал зөвлөмж гэж юу вэ?

АХ-ийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл өгөх эсвэл гүйцэтгэл сайжруулах зорилгоор ашигладаг харилцаа холбооны арга юм.

Гүйцэтгэл сайн үед улам бататгах, гүйцэтгэл тааруу үед сайжруулах зорилгоор ашиглана.

Бүтээлч санал зөвлөмж

- Коучинг хийхэд түлхүү ашигладаг;
- Санал зөвлөмжийг найрсаг, дэмжсэн орчин бүрдүүлж хэлсэн тохиолдолд илүү үр дүнтэй;
- Уураа илэрхийлэх эсвэл шүүмжлэх зорилгоор ашиглахгүй байх;
- Заналхийлж, айлган сүрдүүлэх арга биш АХ-ид сурч, хөгжих боломж гэдгийг ойлгуулах;
- Тасралтгүй сурч хөгжих үйл явц юм;
- Санал зөвлөмжийг бүтээлчээр эв дүйтэй өгсөн тохиолдолд итгэлцэл бүхий шударга, чин сэтгэлийн, бодит харилцааг бий болгож, өсч хөгжихөд нөлөөлдөг.

Онцлог шинж

- Үнэлж дүгнэхээс илүү тайлбарлаж, ухуулж ойлгуулах шинжтэй;
- Ерөнхий бус, тодорхой байна;
- Субъектив биш, факт, зан төлөвт чиглэсэн байна;
- Санал шүүлж өгч, авч байгаа талын хэрэгцээ шаардлагад нийцсэн байна;
- Хүлээж авч буй тал ямар нэгэн арга хэмжээ авах боломжтой асуудал, зан төлөвт чиглэсэн байна.

Онцлог шинж

- Цагаа олсон байх;
- Зөвлөгөө өгөх биш илүү мэдээлэл хуваалцсан шинжтэй;
- Хүлээн авагч талын хүлээн авч чадах хэмжээнд мэдээллийг хуваалцах. Өөрийн зүгээс өгмөөр байгаа бүх мэдээллийг нэг зэрэг өгөхгүй байх;
- Санал зөвлөмжийг хэлэхээс өмнө сайтар эргэцүүлж, бэлтгэл хангасан байх.

- Шулуухан хэлэх
- “хэрэгтэй, шаардлагатай” гэх үгс хэрэглэхээс татгалзах
- Шударга байх
- Эргэлзээ төрүүлэх үгс хэрэглэхгүй байх (..... Гэхдээ..... гэх мэт...)

Хэв маяг

Санал зөвлөмж өгч буй
байдал хамгийн чухал
Хэрхэн яаж илэрхийлэх нь
агуулгаас ялгаагүй нэн
чухал

ВIT арга:

В: Зан төлөв: Тухайн санал зөвлөмжид хамаарах зан төлөвтэй нь холбож тайлбарлах

I: Үр дүн, нөлөө: Эерэгээр үр дүн сайтай ажилласнаар гүйцэтгэлд нь ямар нөлөө үзүүлснийг тайлбарлах

T: Талархал: Гүйцэтгэлийн үр дүнд нь талархал илэрхийлэх.

Эерэг санал зөвлөмж

Эерэг санал зөвлөмжийн
үед Талархлаа илэрхийлэх

Өнгө аяс чухал – Бүтээлч санал зөвлөмж нь шүүмжлэл болж хувирах тохиолдол бий

Гүйцэтгэлтэй холбоотой засаж сайжруулах аливаа асуудлыг таниулах зорилготой.

**Засаж сайжруулах
зорилготой санал зөвлөмж**

Асуудлыг илэрхийлэх

- Хүн бүрийн онцлогт тохирсон санал зөвлөмж өгөх
- Өөрийн таамаглал биш ажиглагдсан зүйлийг хөндөх
 - Бодит факт байх
 - Шүүмжилсэн өгнө аясгүй байх

**Засаж сайжруулах
зорилготой санал зөвлөмж**

**Санаа зовоож буй
асуудлыг илэрхийлэх**

- Бүтээлч санал зөвлөмж нь шүүмжлэл биш гэдгийг ойлгох!
- Санал зөвлөмж өгөхөөс өмнө өөрийн сэтгэлгээний онцлогийг эргэн санах
- АХ-аас яг юуг яагаад хүсч байгаагаа ойлгох
- Өөрөө ямар хандлагатай байгаагаа анзаарах
- Хүргэх гэж буй мэдээллээ нягтлах
- Гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг засаж сайжруулах шаардлагатай тохиолдолд тухай бүр нь санал зөвлөмж өгөх

Бүтээлч санал зөвлөмж

Сайжруулах шаардлагатай
зүйлсийг мэдрэмжтэйгээр
хүргэх

- **B** Засаж сайжруулахаар зорьж буй зан төлөвийг тодорхой хэлэх
- **E** Тухайн зан төлөв ямар нөлөө үзүүлж буйг тайлбарлах
- **E** Тухайн зан төлөвтэй холбоотой ямар хүлээлттэй байгаагаа тодорхой, ойлгомжтой хэлэх
- **R** Тухайн зан төлөвт хамаарах асуудлыг шийдсэнээр ямар үр дүнд хүрэхийг тайлбарлах

Зөрчилдөөн их үүсгэдэг зантай хүмүүстэй ажиллахад ашигладаг алтернатив **BIFF** арга:

- **B** Товч тодорхой байх /сэтгэл хөдлөлт авталгүйгээр/
- **I** Мэдээллийн шинж чанартай байх /факт мэдээлэл/
- **F** Найрсаг өнгө аястай байх
- **F** Байр сууриндаа бат зогсох

BEER арга
(Behavior, Effect, Expectations,
Result)

**Асуудлыг шийдэх зорилгоор
мэдээллээ энэ бүтцийн
дагуу хүргэх**

Хувилбар 1

Бүтээлч бус зан төлөвийг засах бодит жишээ, кэйс.
BEER аргыг ашиглах:

B- зан төлөв **E**-нөлөө **E**- үр дүнгийн хүлээлт **R**- үр дүн

Хувилбар 2

Эерэг зан төлөвийг бататгах зорилгоор бүтээлч санал зөвлөмж өгөх жишээ, кэйс. **BIT** аргыг ашиглах:

B – зан төлөв **I** – нөлөө **T**- талархал

Дасгал ажил

Эерэг зан төлөвийг бататгах

Бүтээлч бус зан төлөвийг засах

Дараах асуултыг асуух:

- Гүйцэтгэлээ сайжруулах чадавхтай эсвэл хүсэл бий юу?
- Дараах шалтгаануудын нэг байх боломжтой:
 1. *АХ-ийн зорилгогүй байх эсвэл өөрийн зорилго, үнэт зүйлс нь байгууллагын соёл, үнэт зүйлстэй уялдахгүй байх*
 2. *АХ дасан зохицох чадваргүй байх, гаргасан алдаа нь өөрийн ур чадвартаа итгэл алдрахад хүргэсэн байх*
 3. *Гүйцэтгэл сул/зан төлөвийн асуудалтай байгаад бусдыг буруутгах – Хувь хүний хариуцлагын мэдрэмжгүй*
 4. *АХ хувийн асуудал, стресстэй байж болно. Сэтгэл зүй, эрүүл мэндийн гэх мэт...*

Гүйцэтгэлтэй холбоотой асуудал үргэлжилсээр байгаа тохиолдолд зан төлөвтэй холбоотой асуудлын учир шалтгааныг олох



Монгол Улс:
Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс
баялгийн менежментийг сайжруулах (MERIT)

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй
дүүрэг, 1-р хороо, Худалдааны гудамж, Нэйшнл
Таймс Ньюс Тауэр, 3-р давхар

Утас: 7610500

www.merit.mn

www.portal.merit.mn